



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 21 өдөр

Дугаар А/88

Хэрлэн сум

Гар зураг, эссэ, дүр бүтээх
уралдааны зардалд хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Боловсролын ерөнхий хууль 30.1.11, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Эх орончдын өдөр"-ийг тохиолдуулан "Миний мэдэх Дамдины Сүхбаатар" сэдвийн хүрээнд суралцагч, залуучуудын дунд зохион байгуулах гар зураг, эссэ, дүр бүтээх уралдааны зардалд зориулан 3,000,000 (гурван сая) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн шагнал урамшуулал, нэг удаагийн буцалтгүй тусламж, дэмжлэгийн зардлаас олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2024 оны
02 дугаар сарын 21-ны
..... дугаар захирамжийн хавсралт

Мөнгөн шагналын тооцоо

№	Уралдааны төрөл	Байр	Мөнгөн шагнал	Нийт
1	Гар зургийн уралдаан	I байр	500,000	500,000
		II байр	300,000	300,000
		III байр	200,000	200,000
2	Дүр бүтээх уралдаан	I байр	500,000	500,000
		II байр	300,000	300,000
		III байр	200,000	200,000
3	ЭССЭ бичлэгийн уралдаан	I байр	500,000	500,000
		II байр	300,000	300,000
		III байр	200,000	200,000
	Нийт			3,000,000